

Судалгааны Тойм

№9 | WWW.FORUM.MN | БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ | СУДАЛГААНЫ САН | ВИДЕО

ХОРИХООС СУЛЛАГДСАН ЭТГЭЭДЭД ХЯНАЛТ ТАВИХ НЬ

ТОВЧ ТАЙЛБАР

Хорихоос суллагдсан этгээдэд хяналт тавих нь нэгдүгээрт, гэмт хэрэг үйлдээд хорих ял эдэлсэн этгээдийг нийгэмд эргэн нэгтгэх үйл явцад туслах буюу нийгэмшүүлэх; хоёрдугаарт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэсэн хоёр үндсэн зорилго агуулдаг. Монгол Улсын Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагын зорилгыг тодорхойлохдоо “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх”¹ гэж тодорхойлсон байдаг.

Монгол Улсад хорихоос суллагдсан этгээдэд хяналт тавих үйл ажиллагаа нь хугацаа дууссан болон хугацаанаас өмнө суллагдсан этгээдэд чиглэгдэх² ба хууль сахиулах чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд болох Шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон цагдаагийн байгууллагууд нь Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай (ГХЗУСтХ), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай (ШШГТХ), Цагдаагийн албаны тухай хуулиуд болон бусад хууль тэрчлэн

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтарсан тушаал зэрэг хууль тогтоомж, эрх зүйн актын дагуу³ гүйцэтгэж байна.

Сүүлийн жилүүдэд дэлхийн хэмжээнд гэмт хэрэгтнийг нийгэмшүүлж, хүмүүжүүлэх асуудал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны анхаарал татсан асуудлын нэг болоод байгаа төдийгүй улс орнуудад гэмт этгээдийг нийгэмшүүлэх ажиллагаа нь эрүүгийн эрх зүйн тогтолцоонд тусгай тогтолцоо болон хөгжиж байна. Тухайлбал, Япон Улсад Пробацийн тогтолцоо маш сайн хөгжиж, гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх, хяналт тавих үйл ажиллагаа нь Азийн бусад орнуудад жишиг болсон. Иймд энэхүү судалгаагаар Монгол Улсад хорихоос суллагдсан этгээдэд хяналт тавьж буй эрх зүйн зохицуулалт, өнөөгийн хэрэгжилт, түүний үр нөлөө ямар төвшинд байгааг илрүүлэх, дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ зарим улсын сайн туршлагыг судалж, цаашид боловсронгуй

¹ Эрүүгийн хууль, 2015 он, 5.1 дүгээр зүйл.

² ГХЗУСтХ-ийн 41.1 дүгээр зүйлд “Эрүүгийн хуулийн 10.1, 11.2, 12.1, 12.3, 15.1, 15.5, 15.6, 16.2, 17.1, 18.6, 19.2, 19.5, 19.6, 19.8, 20.3, 20.7, 20.8, 26.1, 26.2, 26.3, 29.8, 29.10 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж, хоёроос дээш жилийн хугацаагаар хорих ял эдэлж суллагдсан болон хоёроос дээш жилийн хугацаагаар хорих ял эдэлж, Эрүүгийн хуулийн 6.12, 6.13, 6.14 дүгээр зүйлд заасны дагуу хорих ялаас хугацааны өмнө суллагдсан, чөлөөлөгдсөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудад заасан хяналтын хугацаа нь дууссан хүнд гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт тогтооно” гэсэн байдаг.

³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллагын хамтран ажиллах журам, 2014 он, www.legalinfo.mn

болгох санал, зөвлөмж өгөхийг зорилоо. Гэвч энэ судалгаа нь шинэ ГХЗУСтХ хэрэгжиж эхлэхийн өмнө хийгдсэн тул өмнөх хуулийн хэрэгжилтэд илүүтэй үнэлгээ хийсэн болно.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааг захиалагчийн хүсэл зоригоос ангид, бие даасан, хараат бус хандлагаар хийхийг зорьсон бөгөөд эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх, гадаадын зарим орны хууль тогтоомжтой харьцуулах, системчлэх, логик дүгнэлт хийх, задлан шинжилж нэгтгэн дүгнэх зэрэг бичиг баримтын судалгааны арга зүйд үндэслэн

СУДАЛГААНЫ ДҮН

Хууль сахиулах байгууллагын хяналт нь шүүхээс тэнсэн суллагдсан (ял оногдуулахгүйгээр тэнссэн), хорих ялаас хугацаанаас өмнө тэнсэн суллагдсан, насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, жирэмсэн болон 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг хойшлуулсан, хорих ял эдлээд суллагдсан зэрэг 5 төрлийн этгээдэд чиглэсэн байна. Эдгээрээс хорих ял эдлээд суллагдсан этгээд буюу хугацаанаас өмнө эсхүл хугацаа нь дуусаж суллагдсан этгээдэд тавьж буй хяналт бидний судалгааны хүрээнд хамаарах юм.

Хорих ялаас хугацаанаас нь өмнө суллагдахад эдлээгүй үлдсэн ялын хугацаатай тэнцүү хяналтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хэрэгжүүлэх⁴ ба тэрхүү хяналтын хугацаа дууссаны дараагаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн байгууллага

Энэхүү тойм нь судалгааны гол үр дүн, санал, зөвлөмжийг уншигчдад хүргэхийг зорьсон ба судалгааг бүрэн эхээр нь www.forum.mn сайтаас татаж үзнэ үү.

гүйцэтгэсэн болно. Түүнчлэн өнөөгийн нөхцөл байдлыг илрүүлэн тандах зорилгоор иргэд, албан тушаалтны дунд фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын, ажиглалтын, санал асуулгын зэрэг социологийн судалгааны аргуудыг ашиглалаа.

хяналт тогтоож болдог.⁵ Харин хорих ялын хугацаа нь дуусаж суллагдсан этгээдийн тухайд Эрүүгийн хуулийн зарим зүйлд заасан⁶ гэмт хэрэг үйлдэж, хоёроос дээш жилийн хугацаагаар хорих ял эдэлсэн бол суллагдсаны дараагаар ГХЗУСТХ-ийн 41.1 дүгээр зүйлд зааснаар цагдаагийн байгууллага 1-3 жилд хяналт тогтоодог эрх зүйн зохицуулалттай.

Дэлхийн улсууд хорихоос суллагдсан этгээдэд хяналт тавихдаа “хяналт-control” гэхээсээ илүүтэйгээр тусламж дэмжлэг үзүүлэх, нийгэмд эргэн нэгтгэх, нийгэмшүүлэх талаас нь анхааран ажиллах болжээ. Тухайлбал, АНУ-д гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг уялдуулан халамжлах ба хянах гэсэн стратегийг баримтлах болсон.⁷ Олон улсын эрх зүйн баримт бичгүүд, дэлхий нийтийн хандлага хяналтыг халж туслах-нийгэмшүүлэх бодлогод чиглэж байгаа өнөө үед Монгол Улс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

⁴ Эрүүгийн хуулийн 6.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.6 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, www.legalinfo.mn

⁵ ГХЗУСТХ, 2020 он, 41.1 дүгээр зүйл.

⁶ Эрүүгийн хуулийн 10.1, 11.2, 12.1, 12.3, 15.1, 15.5, 15.6, 16.2, 17.1, 18.6, 19.2, 19.5, 19.6, 19.8, 20.3, 20.7, 20.8, 26.1, 26.2, 26.3, 29.8, 29.10 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн бол.

⁷ Риан М Лабрикью, “АНУ дахь пробацион тогтолцооны түүхэн ба орчин үеийн чиг хандлага”, https://pdxscholar.library.pdx.edu/cgi/viewcontent.cgi?article=1029&context=ccj_fac сүүлд зочилсон 2019 оны 8 дугаар сар.

зорилгын хүрээнд тодорхойлогдсон эрх зүйн орчинтой төдийгүй хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал, 1997 оны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар “нийгмийн хэв журам сахих, сард 1 удаа цагдаагийн байгууллагад бүртгүүлэх, байнгын оршин суугаа хаягаа өөрчлөх бол мэдэгдэх зэрэг” арга хэмжээ авдаг болох нь хяналтад байгаа этгээд болон хууль сахиулах ажилтантай хийсэн ярилцлагын судалгаанаас⁸ харагдаж байна. 2020 оноос хэрэгжиж эхэлсэн шинэ ГХЗУСтХ нь хяналтад байгаа этгээдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар ярилцлага хийх, зөвлөгөө өгөх, нийгэмд дасан зохицох, ажил хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх, тодорхой үүрэг өгч, биелэлтийг хангуулах, зан үйл, хөдөлмөр эрхлэлт, үйл ажиллагааны талаар тусгайлсан шаардлага, хориглолт, хязгаарлалт тогтоох, ажил хөдөлмөр эрхлэлтийн байдал, үйл ажиллагааг нь биечлэн шалгах, мансууруулах эм, бодис хэрэглэсэн эсэхийг тодорхойлох арга хэмжээ авах, захиргааны журмаар албадан эмчилгээнд хамруулах зэрэг нэлээд дэвшилттэй зүйл заалтыг хуульчилж өгсөн⁹ хэдий ч хуулийн үзэл баримтлал нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг хандлагатай тул гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх бодлогод төдийлөн нөлөөтэй биш байх магадлалтай. Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 256 дугаар зүйлд хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох гэсэн зүйл байгаа ч тус хуулийн заалтад суллагдсаны дараа хяналт тавих талаар тусгаагүй ба тус хуулийн 187 дугаар зүйлд тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн¹⁰ хяналтыг

заахдаа мөн л гадаадад зорчих, цагаачлахыг хориглож, оршин суугаа засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийг 7 хоногоос дээш хугацаагаар орхин явах тохиолдолд зөвшөөрөл авах, 30 хоног тутамд нэг удаа биечлэн ирж, бүртгүүлэхийг даалгах зэргээр хяналт тогтоосон нь мөн л нийгэмшүүлэх, нийгэмд эргэн нэгтгэх зорилгыг хангаагүй байна.

Гэтэл хорихоос суллагдсан этгээд нийгэмд шилжин орох үед материаллаг байдлын хомсдол, сэтгэл зүйн болон нийгмийн дэмжлэг, төрийн зүгээс авч хэрэгжүүлэх нийгэмшүүлэх үйл ажиллагаа дутагдсан үед тэдний ихэнх нь суллагдахаас зайлсхийх, дахин гэмт хэрэг үйлдэх магадлал өндөр байдаг. Иймд хорихоос суллагдсан этгээдэд тавих хяналтын хэрэгжилт сул, нийгэмшүүлэх үйл ажиллагаа байхгүй тул Монгол Улсад хорихоос суллагдсан этгээдийн дахин гэмт хэрэг үйлдэх хувь өндөр байгаа¹¹ төдийгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа үр дүнд хүрэхгүй байна гэж дүгнэлээ. Эцэст нь дүгнэхэд, Монгол Улс рецидив гэмт хэргийг бууруулах үүднээс хорихоос суллагдсан этгээдэд тавьж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой хяналтыг нийгэмшүүлэх зорилготой нэгтгэнажиллах шаардлагатай. Үүний тулд гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх эрх зүйн зохицуулалтыг тусгайлан баталж, нийгэмшүүлэх ба хяналтын тусгайлсан чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллагууд болох Паролын болон Пробагийн албыг байгуулж, дорвитой шинэтгэл хийх нь зүйтэйг тэмдэглэмээр байна.

⁸ Бидний хийсэн ганцаарчилсан ярилцлагын, фокус бүлгийн судалгаа ГХЗУСтХ хэрэгжиж эхлэхээс өмнө хийгдсэн болно.

⁹ ГХЗУСтХ, 2020 он, 45.2 дугаар зүйл

¹⁰ Тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээд гэдэгт хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан болон хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон этгээдийг хамруулна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 186.2 дугаар зүйл

¹¹ Монгол Улсад 2014 онд 6500 хоригдлын 47.2 хувь, 2018 онд 3500 хоригдлын 1614 буюу 46.1 хувь нь давтан гэмт хэрэг үйлджээ.

ЗӨВЛӨМЖ

1. Хорихоос суллагдсан этгээдийн “шилжилтийн үе”-ийн хүндрэлтэй асуудлууд болох хөдөлмөр эрхлэлт, орон сууц, донтох эмчилгээ болон эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамж, санхүүгийн туслалцаа зэргийг шийдвэрлэхэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд онцгой анхаарч хамтран ажиллах. Түүнчлэн дээрх асуудлыг төрөөс шийдвэрлэх “гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх тусгай сан” бүрдүүлэх талаар буюу нийгмийн хамгааллын тогтолцоог анхаарч үзэх;
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүднээс олон улс болон гадаад орнуудад ашиглаж буй дараах хяналтын үр нөлөөтэй аргуудыг нэвтрүүлж хяналтын хэрэгжилтийг сайжруулах. Тухайлбал архи, хорт бодис, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох ба эдгээрийг хэрэглэж байгаа эсэхийг сорилт тавьж хянах, электрон хяналтын тусламжтайгаар газар зүйн тодорхой байршлуудаас татгалзуулах, бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтний тухайд тусгай эмчилгээний хөтөлбөрт хамруулах, насанд хүрээгүй хүнтэй хамт амьдрахыг хориглох, сэтгэл зүйн үйлчилгээнд хамруулах;¹²
3. ГХЗУСтХ-ийн 45 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагыг сайн дурын үндсэн дээр оролцуулж болно” хэмээн заасан нь

Монгол Улс хорихоос суллагдсан этгээдийг хянах ажиллагаанд иргэд, олон нийтийг оролцуулдаг Япон, Тайланд зэрэг орны сайн туршлагыг нэвтрүүлсэн хэрэг бөгөөд энэ заалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарах;

4. АНУ, Канад зэрэг улсуудын хорих ангиас суллагдаж буй гэмт хэрэгтний ахуй хангамж, сэтгэл зүйн болон бусад онцлогийг харгалзан гэмт хэрэг дахин үйлдэх эрсдэлийн үнэлгээ тогтоодог туршлагыг нэвтрүүлэх нь зүйтэй. Ингэхдээ эрсдэлийн үнэлгээ хийх мэргэжлийн Зөвлөл байгуулж, ажиллах журмыг олон улсын туршлагын дагуу боловсруулж, батлах;
5. Хорихоос суллагдсан, орон гэргүй этгээдийг түр хугацаанд байр, хоолоор хангаж үйлчлэх чиг үүрэг бүхий нийгэмшүүлэх байр байгуулах туршлага Япон, ХБНГУ зэрэг улсад байна. Монгол Улсын хэмжээнд ийм үйлчилгээ үзүүлэх байрыг ажиллуулах боломжийг судлах;
6. Монгол Улсын эрүүгийн процесс шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гэсэн үе шатаар дуусдагийн улмаас хорихоос суллагдсан этгээдийг нийгэмшүүлэх үйл ажиллагаа уялдаа холбоогүй, хариуцах үндсэн бүтэцгүй, эрх зүйн нэгдсэн зохицуулалтгүй явж ирсэн тул “Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх тухай” тусгайлсан хуулийг баталж, нийгэмшүүлэх чиг үүрэг бүхий “Пробацийн болон Паролын алба”-ыг байгуулах.

¹² Канад Улсад өндөр эрсдэл бүхий гэмт хэрэгтэнд электрон гав зүүлгэж GPS буюу хиймэл дагуулаар цахим хяналт тавьдаг туршлага байна.

СУДЛААЧ:

Б.ОДОНГЭРЭЛ, Хууль зүйн магистр

САНАЛ, ШҮҮМЖ ӨГСӨН:

Б.Хишигсайхан, ННФ-ын Хуулийн хөтөлбөрийн менежер



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамьян гүний гудамж-5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240
Утас: (976) 76113207

<http://www.forum.mn>
<http://www.twitter.com/ForumOS>

<http://facebook/OpenSocietyForum>
http://www.instagram.com/open_society_forum